



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/67

Мандалговь

Г Сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг
Т сунгах тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 23 дугаар зүйлийн 23.1, 23.4, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын “Мандал” ерөнхий боловсролын сургуулийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатайгаар сунгасугай.

Хоёр. Боловсролын тухай хууль, Багшийн ёс зүй, өөрсдийн үйл ажиллагаанд холбогдох бусад стандартын хэрэгжилтийг хангаж ажиллахыг “Мандал” ерөнхий боловсролын сургуулийн захирал (М.Энхбаяр)-д үүрэг болгосугай.

Гурав. “Мандал” ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, эрх бүхий байгууллагаас тогтоосон стандарт, норм, нормативыг сахин мөрдөж байгаа эсэхэд байнгын хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа), Боловсрол, соёл, урлагийн газар (Ц.Бумангэрэл)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



488010182